



ᠮᠣᠩᠭᠡᠯᠡ ᠤᠨᠳᠡᠰᠦᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠤ ᠠᠨᠤᠨᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠤ



БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА **2**

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН



ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. ХЯНАСАН

Авирмэдийн Амарбал
Эдийн засагч-Хүн ам зүйч, Хүн ам зүйн ухааны доктор
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга, Хүн ам,
орон сууцны тооллогын Улсын комиссын нарийн бичгийн
дарга

Төмөрбаатарын Болор-Эрдэнэ
Эдийн засагч - Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Чимэдцэрэнгийн Цогтбаяр
Хүн ам зүйн магистр

Мөнх-Эрдэний Энхзориг
Эдийн засагч-Статистикч

ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Энхбаатарын Алтантуяа
Эдийн засагч - Хүн ам зүйч

Батчулууны Ариунзаяа
Эдийн засаг - Менежмент

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
<http://www.nso.mn>
И-мэйл: informationa@nso.mn
Утас: 11-321433

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.



АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	iii
Зургийн жагсаалт	iv
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	1
1.1 Судалгааны зорилго, ач холбогдол	2
1.2 Боловсролын тухай ойлголт, тодорхойлолт	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮН АМЫН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ	6
2.1 Хүн амын боловсролд хамрагдалт.....	7
2.2 Хүн амын сургууль завсардалт	9
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ	14
3.1 Хүн амын боловсролын түвшин	15
3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол	22
3.3 Боловсрол ба шашин.....	26
3.4 Хүн амын бичиг үсгийн мэдлэг	28
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛ	31
4.1 Хүн амын ажил эрхлэлт, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг.....	32
4.2 Ажил эрхэлдэггүй хүн ам болон ажилгүйчүүдийн боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг.....	35
4.3 Эдийн засгийн үйл ажиллагааны салбарт ажилладаг хүн амын боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг.....	39
ТАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМЫН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ.....	43
5.1 Их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжил.....	44
5.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн мэргэжил	53
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	57
ХАВСРАЛТ	61



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.1. Хүн амын суурь боловсролд хамрагдалт	9
Хүснэгт 2.2.1. 6-15 насны нийт хүүхдийн тоо, сургуульд сурдаггүй хүүхдийн тоо, хүйс, аймаг, нийслэл, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он	10
Хүснэгт 2.2.2. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй 2-5 насны хүн амын тоо, хүйс, хот, хөдөөгөөр, 2020 он	11
Хүснэгт 2.2.3. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй 2-5 насны хүн амын тоо, аймгаар, 2020 он	13
Хүснэгт 3.1.1. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, аймаг, нийслэлээр, 2020 он	20
Хүснэгт 3.1.2. Магистр, докторын түвшний боловсролтой хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010, 2020 он	21
Хүснэгт 3.2.1. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, болосролын түвшин, насны бүлэг, хувиар, 2020 он	25
Хүснэгт 3.2.2. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, боловсролын түвшин, аймаг, нийслэл, хувиар, 2020 он	26
Хүснэгт 4.1.1. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, боловсролын түвшин, аймаг, нийслэл, хувиар, 2020 он	35
Хүснэгт 4.2.1. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн ам, боловсролын түвшин, аймаг, нийслэл, хувиар, 2020 он	39
Хүснэгт 5.1.1. Дээд сургууль төгсөгчид, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, мянган хүн, 2020 он	45
Хүснэгт 5.1.2. Дээд сургууль төгсөгчид насны бүлгээр, мэргэжлийн ерөнхий чиглэлд эзлэх хувиар, 2020 он	46
Хүснэгт 5.1.3. Хоёр мэргэжлээр дээд сургууль төгсөгчид насны бүлэг, мэргэжлийн ерөнхий чиглэлд эзлэх хувиар, 2020 он	47
Хүснэгт 5.1.4. Гурван мэргэжлээр дээд сургууль төгсөгчид насны бүлэг, мэргэжлийн ерөнхий чиглэлд эзлэх хувиар, 2020 он	47
Хүснэгт 5.1.5. Дээд сургууль төгсөгчид, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, насны бүлэгт эзлэх хувиар, 2020 он	48
Хүснэгт 5.1.6. Дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, мэргэжлийн ерөнхий чиглэл, хувиар, 2020 он	51
Хүснэгт 5.1.7. Дээд сургууль төгссөн эрэгтэй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, мэргэжлийн ерөнхий чиглэл, хувиар, 2020 он	51
Хүснэгт 5.1.8. Дээд сургууль төгссөн эмэгтэй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, мэргэжлийн ерөнхий чиглэл, хувиар, 2020 он	52
Хүснэгт 5.2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид, мэргэжлийн ангилал, хүйс, хувиар, 2020 он	54
Хүснэгт 5.2.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид, мэргэжлийн ангилалд эзлэх хувиар, насны бүлгээр, 2020 он	55
Хүснэгт 5.2.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид, хөдөлмөр эрхлэлт, хүйс, хувиар, 2020 он	56



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 2.1.1. Хоёроос хорин есөн насны хүн амын сургууль/цэцэрлэгт хамрагдалт, хүйс, хувиар, 2010, 2020 он	7
Зураг 2.1.2. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, хот, хөдөөгөөр, 2020 он	8
Зураг 2.1.3. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010, 2020 он.....	8
Зураг 2.1.4. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, насны бүлэг, хувиар, 2010, 2020 он.....	8
Зураг 2.2.1. Сургуульд сурдаггүй 6-15 насны хүүхэд, хүйс, нас, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	9
Зураг 2.2.2. Сургуульд сурдаггүй 6-15 насны хүүхдийн эзлэх хувь, аймгаар, 2020 он	11
Зураг 2.2.3. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй 2-5 насны хүн амын эзлэх хувь, аймгаар, 2020 он	12
Зураг 3.1.1. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин	15
Зураг 3.1.2. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хувиар, 2020 он	16
Зураг 3.1.3. Арав, түүнээс дээш насны хотын хүн амын боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он.....	17
Зураг 3.1.4. Арав, түүнээс дээш насны хөдөөгийн хүн амын боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он.....	17
Зураг 3.1.5. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, хувиар, 2020 он.....	18
Зураг 3.1.6. Арав, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он.....	18
Зураг 3.1.7. Арав, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он.....	19
ЗУРАГ 3.1.8. Арав, түүнээс дээш насны боловсролгүй хүн ам, насны бүлэг, хувиар, 2010, 2020 он.....	19
Зураг 3.1.9. Арав, түүнээс дээш насны бага боловсролтой хүн ам, аймаг, нийслэл, хувиар, 2010, 2020 он	21
Зураг 3.1.10. Арав, түүнээс дээш насны дээд боловсролтой хүн ам, аймаг, нийслэл, хувиар, 2010, 2020 он	22
ЗУРАГ 3.2.1. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он	23
ЗУРАГ 3.2.2. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, боловсролын түвшин, хүйс, хувиар, 2020 он	24
ЗУРАГ 3.2.3. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, боловсролын түвшин, хот, хөдөө, хувиар, 2020 он	24
ЗУРАГ 3.3.1. Арван тав, түүнээс дээш насны шашин шүтдэг хүн ам, боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он	27
ЗУРАГ 3.3.2. Арван тав, түүнээс дээш насны шашин шүтдэг хүн ам, боловсролын түвшин, хүйс, хувиар, 2020 он	27
Зураг 3.4.1. Хүн амын бичиг үсгийн мэдлэг, хувиар, 1921-2020 он.....	28
Зураг 3.4.2. Хүн амын бичиг үсгийн мэдлэг, насны бүлэг, хувиар, 2020 он.....	29
Зураг 3.4.3. Хүн амын бичиг үсгийн мэдлэг, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	29



Зураг 3.4.4. Хүн амын бичиг үсгийн мэдлэг, хүйс, хувиар, 2020 он.....	30
ЗУРАГ 3.4.5. Хүн амын бичиг үсгийн мэдлэг, аймаг, нийслэл, хувиар, 2020 он..	30
Зураг 4.1.1. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он.....	33
Зураг 4.1.2. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он	33
Зураг 4.1.3. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он	34
ЗУРАГ 4.1.4. Арван тав, түүнээс дээш насны боловсролгүй ажил эрхэлдэг хүн амын бичиг үсгийн мэдлэг, хүйс, хувиар, 2010, 2020 он	34
ЗУРАГ 4.2.1. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй, боловсролгүй хүн амын бичиг үсгийн мэдлэг, хувиар, 2010, 2020 он.....	36
ЗУРАГ 4.2.2. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн ам, боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он	37
ЗУРАГ 4.2.3. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он	37
ЗУРАГ 4.2.4. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, 2010, 2020 он.....	38
ЗУРАГ 4.2.5. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй боловсролгүй хүн амын бичиг үсгийн мэдлэг, хүйс, хувиар, 2010, 2020 он	38
ЗУРАГ 4.3.1. Ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, боловсролын түвшин, хувиар, 2020 он	41
ЗУРАГ 4.3.2. Ажил эрхэлдэг дээд боловсролтой эрэгтэйчүүд, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хувиар, 2020 он.....	42
ЗУРАГ 4.3.3. Ажил эрхэлдэг дээд боловсролтой эмэгтэйчүүд, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хувиар, 2020 он.....	42
ЗУРАГ 5.1.1. Дээд сургууль төгсөгчид, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, хот, хөдөөд эзлэх хувиар, 2020 он.....	49
ЗУРАГ 5.1.2. Хоёр болон гурван мэргэжлээр дээд сургууль төгсөгчид, хот, хөдөө, хувиар, 2020 он	49
ЗУРАГ 5.1.3. Дээд сургууль төгсөгчид, мэргэжлийн ерөнхий чиглэл, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	50
ЗУРАГ 5.1.4. Дээд сургууль төгссөн, хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, мэргэжлийн ерөнхий чиглэл, хувиар, 2020 он	53
ЗУРАГ 5.2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид, насны бүлэг, хувиар, 2020 он.....	53
ЗУРАГ 5.2.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид, мэргэжлийн ангилалд эзлэх хувиар, 2020 он	55



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**СУДАЛГААНЫ ЗОРИЛГО,
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**



1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Монгол Улсын төрөөс Боловсролыг иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж ирсэн.¹

Сүүлийн 10 жилийн хугацаанд боловсролын салбарт үндэсний тусгайлсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн. Тухайлбал, Монгол бичиг (2008-2015 он), Англи хэлний боловсрол (2009-2020 он), Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх (2009-2015 он), Боловсрол (2010-2021 он), Зөв Монгол хүүхэд (2013-2016 он), Англи хэлний үндэсний хөтөлбөр-II (2016-2020 он), Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх (2019-2023 он), Тогтвортой хөгжлийн боловсрол (2018-2022 он) гэх мэт олон үндэсний хөтөлбөрүүдийг дурьдахаар байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д “Хүн болгонд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилт бүхий үйл ажиллагааг 3 үе шаттайгаар төлөвлөж, боловсролын салбарын ирээдүйн чиг хандлага, хөгжлийг тодорхойлох үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон байна.

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл нь:

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ЭРХ ТЭГШ, ТЭГШ ХАМРУУЛСАН БОЛОВСРОЛ	НАСАН ТУРШИЙН ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ	СУРАЛЦАХ СОЁЛ БҮРДСЭН НИЙГЭМ
Хүн болгонд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе	Чанартай боловсрол олгох, насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх үе	Насан туршдаа суралцахуйг дэмжсэн нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлэх үе

Дээрх баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, XXI-р зуунд Монгол Улсын хүн амын боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төр засгийн бодлого, хөтөлбөрийг сайжруулах, боловсронгуй болгоход бодлого боловсруулагчид, судлаач, олон нийтэд хүн амын боловсролын талаар бодитой мэдээллийг хүргэхэд энэхүү сэдэвчилсэн судалгааны ажлын зорилго оршино.

Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнд үндэслэн “Хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэг” сэдэвчилсэн судалгаа хийсэн нь хүүхэд, залуучуудын сургуульд хамрагдалт, завсардалт, хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, эзэмшсэн мэргэжлийг нас, хүйс, байршил, аймаг, нийслэлийн түвшинд тодорхойлж байгаа нь бодлого боловсруулагчид, судлаач, олон нийтэд шаардлагатай мэдээллийн эх үүсвэр

¹ Монгол улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/, 2015 он



болох тул энэхүү сэдэвчилсэн судалгаа нь ихээхэн ач холбогдолтой юм. Энэхүү сэдэвчилсэн судалгаа нь анх удаагаа хүн амын эзэмшсэн мэргэжлийн талаарх мэдээллийг тусгаж өгсөнөөрөө ихээхэн онцлогтой болсон.

1.2 БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 10 дугаар зүйлд “Боловсролын агуулга нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ” гэж заасныг үндэслэн сүүлийн тооллогуудын асуулга, аргачлал, заавар, үр дүн боловсруулсан байдаг.

Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 7 дугаар зүйлд “Бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ”, мөн “Дээд боловсролын тухай” хуулиар “Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120-оос, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна” гэж заажээ.

"Боловсролын түвшин" гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг хэлнэ. Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 11.1 дүгээр зүйлд заасны дагуу боловсролыг түвшинг сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол, дунд боловсрол, дээд боловсрол гэж ангилдаг. Дунд боловсрол нь суурь болон бүрэн дунд боловсрол, дээд боловсрол нь дипломын, бакалаврын, магистрын, докторын гэсэн зэрэглэл /шатлал/-тэй байна.

Боловсролгүй гэж ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.

Бага боловсрол гэж ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн.

Бүрэн бус дунд (суурь) боловсрол 8 буюу 9 жилийн сургалтын агуулгын түвшинг ойлгоно. Тухайлбал, ЕБС-ийн бүтэц 4+4+2 байсан үед суурь боловсролд 8, ЕБС-ийн бүтэц 5+4+2 болон 6+3+3 болсон үед суурь боловсролд 9 жилийн сургалтын агуулгыг тус тус ойлгоно. ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн.

Бүх нийтийн ерөнхий боловсрол буюу Бүрэн дунд боловсрол гэж 10, 11, 12 жилийн сургалтын агуулгын түвшинг ойлгоно. Тухайлбал, ЕБС-ийн бүтэц 4+4+2 байсан үед бүх нийтийн ерөнхий боловсролд 10 жилийн, ЕБС-ийн бүтэц 5+4+2 байсан үед бүх нийтийн ерөнхий боловсролд 11 жилийн, ЕБС-ийн бүтэц 6+3+3



болсон үед бүх нийтийн ерөнхий боловсролд 12 жилийн сургалтын агуулгын түвшинг тус тус ойлгоно. ЕБС-ийн 10 дугаар ангийг 2005 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006-2014 онуудад, 12 дугаар ангийг 2015 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн.

Техникийн болон мэргэжлийн боловсрол гэж мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн.

Тусгай мэргэжлийн дунд боловсрол гэж гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн.

Дээд боловсрол гэж гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

Албан боловсрол гэж боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа юм.

Албан бус боловсрол гэж боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа юм.

Бичиг үсгийн мэдлэг гэж аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг хэлнэ.

Бичиг үсэг мэддэггүй гэж аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг хэлнэ.

"Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин" -ийг тодорхойлохдоо бага, дунд, дээд боловсролтой болон бичиг үсэг мэддэг насанд хүрэгчдийн тооны нийлбэрийг тухайн насны хүн амын тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ. Энэхүү хувийг 100-д хуваан тоогоор илэрхийлснийг "Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын амжилт /тайлагдалт/-ын индекс" гэнэ.

"Сургуульд хамран сургалтын хувь"-ийг тодорхойлохдоо бага, дунд, дээд боловсрол олгодог бүх шатны сургуульд суралцаж байгаа суралцагчдын тоог сургуулийн насны хүн амын тоонд хувааж, хувиар илэрхийлнэ. Хүүхдийн сургуульд элсэх наснаас хамаарч 2000 оныг хүртэл 8-22 насны, 2010 оноос 6-22



насны хүн амыг хамруулж энэхүү үзүүлэлтийг тооцож байна. Харин **"Сургуульд хамран сургалтын индекс"**-ийг тодорхойлохдоо сургуульд хамрагдагсдын хувийг 100-д хувааж тоогоор илэрхийлнэ.

Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жинг: Бүх хэв шинжийн ЕБС-д суралцаж байгаа 8-15 (2004 он хүртэл), 7-15 (2005-2007он), 6-15 (2008 оноос) насны хүүхдийн тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ. Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жинг 100-д хувааж тоогоор илэрхийлснийг **Суурь боловсролын хамран сургалтын индекс** гэнэ.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН АМЫН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ



2.1 ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогод сургуульд суралцаж байгаа болон цэцэрлэгт хүмүүжиж байгаа эсэхийг 2-39 насны хүмүүсээс асуусан.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын зөвлөмжийн дагуу сургуульд суралцах насыг 5-29 насаар тодорхойлох ёстой боловч манай улсын боловсролын шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсүүлэх болсонтой холбогдуулан сургуульд хамрагдалтыг 6-29 насаар авлаа.


Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр манай улсын 6-29 насны хүн амын 72.6 хувь нь, эрэгтэйчүүдийн 71.5 хувь нь, эмэгтэйчүүдийн 73.8 хувь нь ямар нэг түвшний боловсрол олгох сургуульд хамрагдаж байсан байна (Зураг 2.1.1).

Сүүлийн 10 жилд 6-29 насны хүн амын сургуульд хамрагдалт 14.5 пунктээр, үүнээс эрэгтэйчүүдийнх 15.8 пунктээр, эмэгтэйчүүдийнх 13.2 пунктээр тус тус өссөн байна. Ялангуяа 6-17 насны буюу ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин улсын хэмжээнд 98.0 хувь, хүйсийн хувьд эрэгтэйчүүд 97.6 хувь, эмэгтэйчүүд 98.3 хувь байна.

Сургуулийн өмнөх боловсролд 2–5 насны хүүхдийн 84.1 хувь нь хамрагдаж байгаа бөгөөд 2010 оноос 24.0 пунктээр өсжээ. Байршлаар харвал хөдөөд 2-5 насны хүүхдүүдийн 83.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нь өмнөх тооллогоос 38.0 пунктээр өссөн эерэг үзүүлэлттэй байна (Зураг 2.1.1).

Өмнөх тооллогоор 6-29 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтын зөрүү 4.9 пункт байсан бол 2020 онд энэ зөрүү 2.2 пункт болж 2.7-гоор буурсан байна. Өөрөөр хэлбэл, эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт нэмэгдэж зөрүү багассан байна.

ЗУРАГ 2.1.1 ХОЁРООС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬ/ЦЭЦЭРЛЭГТ ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН



2020 оны ээлжит тооллогоор 6-29 насны хотын хүн амын 73.7 хувь нь сургуульд хамрагдсан бөгөөд 2010 оноос 14.5 пунктээр, хөдөөгийн хүн амын 70.6 хувь нь сургуульд хамрагдаж өмнөх тооллогоос 16.8 пунктээр өссөн байна. Өмнөх тооллогын дүнгээр 6-29 насны хотын хүн амын сургуульд хамрагдалт хөдөөгөөс




6.3 пунктээр их байсан бол 2020 онд 3.1 хувь болж 3.2 пунктээр буурсан байна. Хот, хөдөөгийн 6-29 насны хүн амын сургуульд хамрагдалтын зөрүү сүүлийн 10 жилийн хугацаанд эрс багассан байна.

ЗУРАГ 2.1.2. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН




6-29 насны хотын хүн амын сургуульд хамрагдалтыг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн 73.6 хувь, эрэгтэйчүүдийн 73.8 хувь, хөдөөгийн эрэгтэйчүүдийн 67.4 хувь, эмэгтэйчүүдийн 74.1 хувь сургуульд хамрагдаж байна. Өмнөх тооллогын мэдээллээс харахад хотын эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт хөдөөнөөс 4.0 пунктээр илүү байсан бол 2020 оны тооллогоор 0.5 пунктээр бага болсон байна (Зураг 2.1.3).

ЗУРАГ 2.1.3. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН



Хүн амын сургуульд хамрагдалтыг насны ангиллаар үзвэл 6-12 насанд 97.9 хувь, 13-15 насанд 99.0 хувь, 16-18 насанд 93.5 хувь, 19-23 насанд 63.9 хувь, 24-29 насанд 19.7 хувь нь хамрагдаж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд 19-23 насныхны сургуульд хамрагдалт хамгийн их (24.2 пункт)-ээр нэмэгджээ (ЗУРАГ 2.1.4).

ЗУРАГ 2.1.4. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН





Боловсролын тухай хуульд заасны дагуу “Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших” үүрэгтэй тул иргэдийн суурь боловсролын хамран сургалтын байдлыг сүүлийн 40 жилээр авч үзэхэд 8-15, 6-15 насны хүн амын суурь боловсролд хамрагдалтын хувийн жин 1990 онд 93.5 хувь байсан бол 2000 онд 80.6 хувь болж 12.9 пунктээр буурч байсан бол 2010 онд 96.4 хувь болж өмнөх тооллогоос 15.8 пунктээр өссөн байна. Харин 2020 онд 6-15 насны хүн амын суурь боловсролд хамрагдалтын хувийн жин 98.1 хувь болж өмнөх тооллогоос 1.7 пунктээр өссөн байна. Суурь боловсролд хамрагдалтын түвшинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийнх 97.9 хувь болж өмнөх тооллогоос 0.5 пунктээр буурсан бол эмэгтэйчүүдийнх 98.3 хувь болж өмнөх тооллогоос 3.8 пунктээр өссөн дүнтэй байна (Хүснэгт 2.1.1). Хүн амын суурь (хуучнаар бүрэн бус дунд) боловсролын хамрагдалт 1990 оноос 2000 онд бууралттай гарсан нь нийгэм, эдийн засагт шилжилтийн үе байсантай холбоотой байх талтай юм.


ХҮСНЭГТ 2.1.1. ХҮН АМЫН СУУРЬ СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Он	8-15 /6-15/ насны хүн ам, мянга			Сургуульд сурдаг хүн амын тоо, мянга			Суралцагчдын нийт хүн амд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
1990	404.8	203.3	201.6	378.5	182.1	196.4	93.5	89.6	97.4
2000	561.1	282.3	278.8	452.2	219.0	233.3	80.6	77.6	83.7
2010	460.5	226.9	233.7	444.0	223.2	220.8	96.4	98.4	94.5
2020	602.0	307.3	294.8	590.7	300.9	289.8	98.1	97.9	98.3

2.2 2-15 НАСНЫ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТЫН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын суурин хүн амын 602.0 мянга буюу 21.4 хувийг 6-15 насны хүүхэд эзэлж байна. 6-15 насны хүн амын 11.4 мянга (1.9 хувь) нь сургуульд суралцахгүй байгаа бөгөөд өмнөх тооллогоос 5.2 мянгаар (1.7 пунктээр) буурсан байна. 6-15 насны сургуульд сурдаггүй хүүхдийн 8.0 мянга (70.2 хувь) нь хот, 3.4 мянга (29.8 хувь) нь хөдөөний хүүхэд байна.

ЗУРАГ 2.2.1. СУРГУУЛЬД СУРДАГГҮЙ 6-15 НАСНЫ ХҮҮХЭД, ХҮЙС, НАС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН





Өмнөх тооллогоор 6-15 насны сургуульд сурдаггүй хүүхдийн 63.0 хувь нь эрэгтэй байсан бол 2020 оны тооллогоор 55.9 хувь болж 7.1 пунктээр буурчээ.

ХҮСНЭГТ 2.2.1. 6-15 НАСНЫ НИЙТ ХҮҮХДИЙН ТОО, СУРГУУЛЬД СУРДАГГҮЙ ХҮҮХДИЙН ТОО, ХҮЙС, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Аймаг, нийслэл	2010 он			2020 он		
	6-15 насны хүүхэд	Сургуульд сурдаггүй	Эзлэх хувь	6-15 насны хүүхэд	Сургуульд сурдаггүй	Эзлэх хувь
БҮГД	460 537	16 553	3.6	602 018	11 351	1.9
Архангай	17 569	915	5.2	17 755	142	0.8
Баян-Өлгий	20 648	1 764	8.5	21 791	1 362	6.3
Баянхонгор	15 853	777	4.9	17 075	155	0.9
Булган	10 163	324	3.2	10 903	135	1.2
Говь-Алтай	11 046	361	3.3	11 100	110	1.0
Дорноговь	10 437	294	2.8	13 642	106	0.8
Дорнод	12 222	344	2.8	15 656	73	0.5
Дундговь	7 958	239	3.0	8 278	60	0.7
Завхан	13 496	465	3.4	13 879	122	0.9
Өвөрхангай	20 977	1 172	5.6	22 049	293	1.3
Өмнөговь	10 056	303	3.0	12 866	109	0.8
Сүхбаатар	9 821	499	5.1	11 516	85	0.7
Сэлэнгэ	17 788	523	2.9	19 906	166	0.8
Төв	15 059	546	3.6	17 104	142	0.8
Увс	17 236	981	5.7	17 251	221	1.3
Ховд	17 472	725	4.1	18 031	320	1.8
Хөвсгөл	22 668	1 304	5.8	26 186	414	1.6
Хэнтий	13 140	348	2.6	14 504	147	1.0
Дархан-Уул	15 110	336	2.2	18 809	136	0.7
Орхон	15 124	298	2.0	18 803	94	0.5
Говьсүмбэр	2 472	53	2.1	3 530	21	0.6
Улаанбаатар	164 222	3 982	2.4	271 384	6 938	2.6

2020 оны тооллогоор сургуульд сурдаггүй хүүхдийг 6-15 насны нийт хүүхдэд эзлэх хувийг аймгаар харвал, Баян-Өлгийд 6.3 хувь, Ховдод 1.8 хувь, Хөвсгөлд 1.6 хувь, Увсад 1.3 хувь, Өвөрхангайд 1.3 хувь, Булганд 1.2 хувь нь суралцахгүй байна. Харин Улаанбаатар хотод 2.6 хувь байна.

Өмнөх тооллогоор 6-15 насны хүүхдэд эзлэх сургуульд сурдаггүй хүүхдийн хувь Архангай аймгийнх 5.2 хувь байсан бол 2020 онд 0.8 хувь болж 4.4 пунктээр, Увс аймгийнх 5.7 хувь байсан бол 2020 онд 1.3 хувь болж 4.4 пунктээр, Өвөрхангай аймгийнх 5.6 хувь байсан бол 2020 онд 1.3 хувь болж 4.3 пунктээр тус бүр буурсан нь хамгийн өндөр бууралтууд байлаа.



ЗУРАГ 2.2.2. СУРГУУЛЬД СУРДАГГҮЙ 6-15 НАСНЫ ХҮҮХДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМГААР, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 2-5 насны нийт 312.2 мянган хүүхдийн 49.6 мянга (15.9 хувь) нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна. Нийт сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадаагүй хүүхдүүдийн 26.3 мянга (53.0 хувь) нь эрэгтэй, 23.3 мянга (47.0 хувь) нь эмэгтэй хүүхэд байна. Тэдгээрийн 2 хүүхэд тутмын нэг нь буюу 52.2 хувь нь 2 нас, 23.4 хувь нь 3 нас, 14.6 хувь нь 4 нас, 9.8 хувь нь 5 настай хүүхдүүд байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй нийт хүүхдүүдийн 68.9 хувь нь хот, 31.1 хувь нь хөдөөгийн хүүхэд байна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор 2 настай 74.4 мянган хүүхэд байгаа бөгөөд 25.9 мянга буюу 34.8 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадаагүй байна. Энэ нь нэг талаараа цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгааг илэрхийлж байна.


ХҮСНЭГТ 2.2.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДААГҮЙ 2-5 НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	49 621	26 278	23 343	34 207	18 013	16 194	15 414	8 265	7 149
2	25 911	13 619	12 292	17 582	9 191	8 391	8 329	4 428	3 901
3	11 627	6 209	5 418	8 089	4 309	3 780	3 538	1 900	1 638
4	7 244	3 897	3 347	5 111	2 715	2 396	2 133	1 182	951
5	4 839	2 553	2 286	3 425	1 798	1 627	1 414	755	659



2-5 хүртэлх насны хүүхдэд эзлэх сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдийн хувь Баян-Өлгийд 33.1 хувь, Ховдод 19.6 хувь, Дундговьд 18.8 хувь, Хөвсгөл болон Улаанбаатар хотод 17.8 хувь байгаа нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 2.2.3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДААГҮЙ 2-5 НАСНЫ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМГААР, 2020 ОН



Тоон мэдээллээс харахад ихэнх аймгуудад 2 настай 2 хүүхэд тутмын нэг нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна (ХҮСНЭГТ 2.2.4).

Баян-Өлгий аймгийн хувьд бусад аймгуудаас ихээхэн онцлогтой харагдаж байгаа бөгөөд СӨБ-д хамрагдаагүй 2-5 настай нийт хүүхдийн 38.8 хувь нь 2 настай, 24.5 хувь нь 3 настай, 19.9 хувь нь 4 настай, 16.9 хувь нь 5 настай хүүхдүүд байна. Харин Сүхбаатар аймгийн СӨБ-д хамрагдаагүй 2-5 насны хүүхдийн 83.5 хувь нь 2 настай, 11.8 хувь нь 3 настай, 2.7 хувь нь 4 настай, 2.0 хувь нь 5 настай хүүхдүүд байна.

Улаанбаатар хотын 2-5 насны сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдийн 49.7 хувь нь 2 настай, 24.1 хувь нь 3 настай, 15.7 хувь нь 4 настай, 10.6 хувь нь 5 настай хүүхдүүд байна. Мөн Улаанбаатар хотын 2 настай 3 хүүхэд тутмын нэг нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна.



ХҮСНЭГТ 2.2.3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДААГҮЙ 2-5 НАСНЫ ХҮН АМЫН ТОО, АЙМГААР, 2020 ОН

Аймаг, нийслэл	2-5 насны хүүхэд	СӨБ-д хамрагдаагүй хүүхэд	Эзлэх хувь, насаар			
			2 нас	3 нас	4 нас	5 нас
БҮГД	312 129	49 621	52.2	23.4	14.6	9.8
Архангай	8 800	1 088	61.0	19.5	12.1	7.4
Баян-Өлгий	10 946	3 619	38.8	24.5	19.9	16.9
Баянхонгор	8 249	628	68.0	18.6	9.1	4.3
Булган	5 397	906	58.5	22.3	11.6	7.6
Говь-Алтай	4 767	508	64.2	19.1	7.9	8.9
Дорноговь	6 624	653	56.4	21.7	13.5	8.4
Дорнод	8 035	1 287	63.9	24.6	8.1	3.5
Дундговь	4 216	791	57.6	24.3	13.8	4.3
Завхан	6 278	749	58.3	22.4	12.4	6.8
Өвөрхангай	10 754	1 136	60.6	17.1	13.3	9.1
Өмнөговь	6 722	1 004	54.4	23.1	15.4	7.1
Сүхбаатар	6 089	448	83.5	11.8	2.7	2.0
Сэлэнгэ	9 495	1 454	55.1	22.8	14.2	7.9
Төв	8 601	986	64.8	20.2	9.8	5.2
Увс	8 181	789	64.6	21.7	8.2	5.4
Ховд	8 587	1 682	48.2	27.2	15.6	9.0
Хөвсгөл	12 248	2 183	52.3	24.7	13.6	9.4
Хэнтий	7 250	849	60.0	24.3	11.2	4.6
Дархан-Уул	9 585	1 156	53.6	23.4	12.9	10.1
Орхон	9 614	914	56.1	21.8	13.2	8.9
Говьсүмбэр	1 819	101	62.4	18.8	8.9	9.9
Улаанбаатар	149 872	26 690	49.7	24.1	15.7	10.6



ГУРАВДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ



3.1 ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН


Энэхүү судалгаанд хүн амын боловсролын түвшинг олон улсын жишиг, өмнөх тооллоготой зэрэгцүүлэхүйц байдлаар 10, түүнээс дээш насаар, бичиг үсгийн мэдлэгийг 15, түүнээс дээш насаар тус тус тооцож гаргасан.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 10, түүнээс дээш насны хүн амын 95.1 хувь нь ямар нэг боловсролтой, үлдсэн 4.9 хувь нь боловсролгүй байна. Боловсролгүй хүний хувь өмнөх тооллогоос 2.6 пунктээр буурсан дүнтэй байна.

2020 онд 10, түүнээс дээш настай нийт хүн амын 13.7 хувь нь бага, 17.1 хувь нь суурь, 29.2 хувь нь бүрэн дунд, 8.6 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн (техникийн 3.9 хувь, тусгай мэргэжлийн 4.7 хувь), 24.2 хувь нь дипломын болон бакалаврын дээд (дипломын 1.1 хувь, бакалаврын 23.1 хувь), 2.1 хувь нь магистр, 0.1 хувь нь докторын түвшний боловсролтой байна.

10, түүнээс дээш насны хүн амд дээд боловсролтой хүн амын эзлэх хувь 2010 оны тооллогын дүнгээс 8.2 пунктээр өссөн бол бага боловсролтой хүний хувь 2.0 пунктээр, суурь боловсролтой хүний хувь 0.8 пунктээр, бүрэн дунд боловсролтой хүний хувь 2.8 пунктээр тус бүр буурсан байна. Энэ нь иргэд бүрэн дунд боловсрол эзэмшээд зогсох бус дээд боловсрол эзэмших эрмэлзэл нэмэгдсэн, нөгөө талаас их, дээд сургууль, коллежийн тоо харьцангуй олон болсноор иргэдийн дээд боловсрол эзэмших боломж нэмэгдсэнтэй холбоотой юм. Тухайлбал, захиргааны тоон мэдээллээс харахад 2010-2011 оны хичээлийн жил 13 их сургууль байсан бол 2019-2020 оны хичээлийн жилд 35 болж даруй 2.7 дахин нэмэгдсэн байна.²

ЗУРАГ 3.1.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



Хүн амын боловсролын түвшинг байршлаар үзвэл мөн л суурь, бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын эзлэх хувь давамгайлж байна.

10, түүнээс дээш настай хотын хүн амын 10.0 хувь нь бага, 11.2 хувь нь суурь, 32.3 хувь нь бүрэн дунд, 9.1 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн (техникийн 3.6 хувь, тусгай мэргэжлийн 5.5 хувь), 33.1 хувь нь дээд боловсролтой байна. Харин хөдөөгийн 10, түүнээс дээш настай хүн амын 21.2 хувь нь бага, 29.0

² УСХ-ны Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмчийн салбарын танилцуулга, 2019 он, (Х35)




хувь нь суурь, 22.9 хувь нь бүрэн дунд, 7.6 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн (техникийн 4.5 хувь, тусгай мэргэжлийн 3.1 хувь), 13.0 хувь нь дээд боловсролтой байна (ЗУРАГ 3.1.2).

Тооллогын дүнгээс харахад дээд боловсролтой хүн амын хувийн жин хотод хөдөөгөөс 2.5 дахин өндөр, харин бага боловсролтой хүн амын хувийн жин хөдөөд, хотоос 2.1 дахин, суурь боловсролтой хүн амынх 2.6 дахин илүү байна.

Үүнээс үзэхэд хөдөөд бага болон суурь боловсролтой хүн амын хувийн жин хотоос нэлээд илүү, харин бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын хувийн жин эсрэгээр хотод нэлээд илүүг харуулж байна

ЗУРАГ 3.1.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН



2010 оны тооллогын дүнгээр бүрэн дунд боловсролтой хотын хүн амын хувийн жин хөдөөгөөс 18.0 пунктээр илүү байсан бол 2020 онд 9.4 пункт болж зөрүү багассан байна. Мөн 2010 оны тооллогоор хотын дээд боловсролтой хүн амын хувийн жин хөдөөгөөс 16.4 пунктээр илүү байсан бол 2020 онд зөрүү 20.1 пункт болж нэмэгдсэн.

2010 оны тооллогоор 10, түүнээс дээш насны хотын хүн амын 23.4 хувь нь дээд боловсролтой байсан бол 2020 онд 33.1 хувь болж 9.7 пунктээр өссөн байна. Харин бүрэн дунд боловсролтой хүн ам 2010 оны тооллогоор 37.6 хувь байсан бол 2020 онд 32.3 хувь болж 5.3 пунктээр буурсан байна. Хотын боловсролгүй хүн амын эзлэх хувь 2020 онд 4.3 болж, өмнөх тооллогоос 0.6 пунктээр буурсан байна (ЗУРАГ 3.1.3).




ЗУРАГ 3.1.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХОТЫН ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



2010 оны тооллогоор 10, түүнээс дээш насны хөдөөгийн хүн амын 7.0 хувь нь дээд боловсролтой байсан бол 2020 онд 13.1 хувь болж 6.1 пунктээр өссөн байна. Харин хөдөөгийн бага боловсролтой хүн ам 2010 оны тооллогоор 26.6 хувь байсан бол 2020 онд 21.2 хувь болж 5.4 пунктээр буурсан байна. Мөн бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролтой хүн амын хувь өссөн байна. Хөдөөгийн боловсролгүй хүн амын эзлэх хувь 2010 онд 13.1 байсан бол 2020 оны тооллогоор 6.2 болж 6.9 пунктээр буурсан байна (ЗУРАГ 3.1.4). Энэ нь хөдөөгийн хүн амын боловсролын түвшин нэмэгдэж байгааг харуулж байна.

ЗУРАГ 3.1.4. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН




Хүн амын боловсролын түвшинг хүйсээр авч үзвэл 10, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн 5.3 хувь нь боловсролгүй, 14.6 хувь нь бага, 19.2 хувь нь суурь, 30.7 хувь нь бүрэн дунд, 8.4 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн (техникийн 4.3 хувь, тусгай мэргэжлийн 4.1 хувь), 21.7 хувь нь дээд боловсролтой байна. Харин эмэгтэйчүүдийн 4.6 хувь нь боловсролгүй, 12.8 хувь нь бага, 19.2 хувь нь суурь, 30.7 хувь нь бүрэн дунд, 8.7 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн (техникийн 3.4 хувь, тусгай мэргэжлийн 5.3 хувь), 31.1 хувь нь дээд боловсролтой байна (ЗУРАГ 3.1.5). 2010 оны тооллогын дүнгээр дээд боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 5.9 пунктээр бага байсан бол 2020 онд энэ зөрүү 9.4 пункт болж нэмэгдсэн байна.



Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг хүйсээр ангилж үзэхэд бүрэн дундаас доош боловсролтой эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйгээс илүү, харин тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйгээс илүү байна (ЗУРАГ 3.1.5).


Мөн 10, түүнээс дээш насны дээд боловсролтой хүн амын 4.3 хувь нь дипломын дээд, 87.1 хувь нь бакалаврын дээд, 8.0 хувь нь магистр, 0.5 хувь нь докторын зэрэгтэй байна. 2020 оны тооллогын дүнгээс харахад дипломын болон бакалаврын дээдтэй 5 хүн тутмын 3 (дипломын 60.6 хувь, бакалаврын 59.7 хувь) нь, магистрын дипломтой 3 хүн тутмын 2 (65.8 хувь) нь эмэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр түвшний боловсрол эзэмшиж байгааг харуулж байна. Харин 2020 оны тооллогоор докторын зэрэгтэй 3 433 хүн тоологдсон бөгөөд үүний 1 684 (49.1 хувь) нь эрэгтэй, 1 749 (50.9 хувь) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3.1.5. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН



Өмнөх тооллогын дүнгээр 10, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн 15.3 хувь нь дээд боловсролтой байсан бол 2020 онд 21.7 хувь болж 6.4 пунктээр өсжээ. Мөн техникийн болон мэргэжлийн боловсролтой эрэгтэйчүүдийн хувийн жин 1.3 пунктээр өссөн бол бага боловсрол 2.0 пунктээр, суурь боловсрол 1.1 пунктээр, бүрэн дунд боловсрол 1.5 пунктээр, тусгай мэргэжлийн дунд боловсрол эзэмшин хүний хувийн жин 0.5 пунктээр тус бүр буурсан байна.


ЗУРАГ 3.1.6. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН






2010 оны тооллогоор эмэгтэйчүүдийн 21.2 хувь нь дээд боловсролтой байсан бол 2020 онд 31.1 хувь болж 9.9 пунктээр өссөн байна. Харин бүрэн дунд 4.1 пунктээр, бага боловсрол 2.2 пунктээр, тусгай мэргэжлийн дунд боловсролд 1.6 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 3.1.7. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



Арав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амыг насны бүлгээр авч үзэхэд, 64.9 хувь нь 10-14 насныхан, 6.9 хувь нь 15-24 насныхан, 7.9 хувь нь 25-34 насныхан, 8.3 хувь нь 35-44 насныхан, 6.5 хувь нь 45-59 насныхан, 5.5 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна. 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 10-14 насныхан 16.0 пунктээр, 35-44 насныхан 2.8 пунктээр өссөн байна (ЗУРАГ 3.1.8). энэ нь боловсролгүй хүн ам буурсан бөгөөд 10-14 насныхан хараахан боловсрол эзэмшиж амжаагүй байгаатай холбоотой.

ЗУРАГ 3.1.8. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 10, түүнээс дээш насны хүн амын 95.1 хувь нь боловсролтой байна. Боловсролтой хүн амын эзлэх хувийг аймгуудаар авч үзвэл Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Говьсүмбэр, Булган аймгуудын 10, түүнээс дээш настай хүн амын боловсролын түвшин улсын дунджаас 0.2-0.9 пунктээр, Улаанбаатар хотын хувьд улсын дунджаас 0.8 пунктээр өндөр байна (ХҮСНЭГТ 3.1.1).



Баян-Өлгий, Дорноговь, Өмнөговь, Ховд, Говьсүмбэр аймгуудын 10, түүнээс дээш насны 5 хүн тутмын нэг нь, Дархан-Уул, Орхон аймгийн 4 хүн тутмын нэг нь, Улаанбаатар хотын 3 хүн тутмын нэг нь дээд боловсролтой байгаа нь бусдаасаа өндөр үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 3.1.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Боловс- ролгүй	Боловсролын түвшин						
		Боловс- ролтой	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Техник болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
БҮГД	4.9	95.1	13.7	17.1	29.2	3.9	4.7	26.5
Архангай	5.2	94.8	20.9	27.5	25.0	3.5	3.1	14.8
Баян-Өлгий	7.0	93.0	21.5	22.1	22.0	4.1	3.1	20.2
Баянхонгор	5.4	94.6	17.5	30.3	24.7	4.2	3.0	14.9
Булган	4.7	95.3	15.9	28.2	27.2	3.5	3.7	16.8
Говь-Алтай	5.5	94.5	18.7	24.9	24.4	4.8	3.5	18.2
Дорноговь	5.1	94.9	14.7	20.8	25.9	5.9	6.0	21.6
Дорнод	5.2	94.8	14.2	23.8	28.5	5.0	5.4	17.9
Дундговь	5.8	94.2	21.9	28.4	18.7	5.3	4.2	15.7
Завхан	7.5	92.5	18.7	23.1	24.4	4.5	3.4	18.4
Өвөрхангай	5.6	94.4	24.4	27.2	21.9	3.7	2.7	14.5
Өмнөговь	5.5	94.5	15.9	23.3	25.1	4.8	4.2	21.2
Сүхбаатар	7.1	92.9	20.6	27.2	19.7	6.9	4.4	14.1
Сэлэнгэ	4.3	95.7	12.0	21.6	33.3	6.2	5.3	17.3
Төв	4.5	95.5	15.0	27.5	26.2	5.9	4.5	16.4
Увс	7.3	92.7	20.7	23.2	22.7	5.3	3.2	17.6
Ховд	6.3	93.7	16.9	22.9	25.6	3.5	4.6	20.1
Хөвсгөл	7.0	93.0	22.2	22.8	28.0	2.4	3.1	14.5
Хэнтий	6.2	93.8	17.1	26.9	26.6	4.0	3.5	15.9
Дархан-Уул	4.0	96.0	10.5	13.7	32.2	5.7	6.5	27.4
Орхон	4.2	95.8	10.3	11.6	35.1	4.5	5.7	28.6
Говьсүмбэр	4.5	95.5	13.9	17.8	28.5	5.4	6.9	23.0
Улаанбаатар	4.1	95.9	9.2	9.4	32.7	3.0	5.3	36.3

2020 оны тооллогын дүнгээр магистрын түвшний дээд боловсролтой хүн ам 51.7 мянга болж өмнөх тооллогоос 21.0 мянга буюу 68.4 хувиар нэмэгдсэн байна. Магистрын түвшний дээд боловсролтой хүмүүсийг хүйсээр авч үзвэл, 2010 оны тооллогоор 39.4 хувь нь эрэгтэй, 60.6 хувь эмэгтэйчүүд байсан бол 2020 оны тооллогоор 34.2 хувь нь эрэгтэй, 65.8 хувь нь эмэгтэйчүүд болсон байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэйгээр үргэлжлүүлэн суралцаж, өндөр боловсрол эзэмших хандлагатай байна. Магистрын түвшний дээд боловсролтой хүн амыг насны бүлгээр нь авч үзвэл, 17.3 хувь нь 20-29 насныхан, 42.2 хувь нь 30-39 насныхан, 24.9 хувь нь 40-49 насныхан, 11.0 хувь нь 50-59 насныхан, 4.6 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна (ХҮСНЭГТ 3.1.2).

Мөн 2020 оны тооллогын дүнгээр докторын түвшний боловсролтой хүн ам 3.4 мянга болж өмнөх тооллогоос 1.0 хувиар өссөн. Докторын түвшний дээд боловсролтой хүн амыг насны бүлгээр нь авч үзвэл, 1.1 хувь нь 25-29 насныхан,



18.1 хувь нь 30-39 насныхан, 28.0 хувь нь 40-49 насныхан, 22.8 хувь нь 50-59 насныхан, 29.9 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна.

ХҮСНЭГТ 3.1.2. МАГИСТР, ДОКТОРЫН ТҮВШНИЙ БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Магистр				Доктор			
	2010		2020		2010		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	30 667	18 570	51 656	33 996	3 399	1 417	3 433	1 749
20-24	1 421	938	1 342	889	-	-	-	-
25-29	5 244	3 381	7 615	5 111	82	53	38	20
30-34	5 732	3 738	12 129	8 084	260	144	229	135
35-39	4 729	3 061	9 667	6 245	389	231	394	220
40-44	4 099	2 579	7 666	5 163	411	235	493	303
45-49	3 999	2 352	5 188	3 583	482	263	467	274
50-54	2 867	1 558	3 240	2 207	531	224	389	243
55-59	1 383	617	2 449	1 540	423	131	395	236
60+	1 193	346	2 360	1 174	821	136	1 028	318

Бага боловсролтой арав, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн өөрчлөлтийг өмнөх тооллоготой харьцуулж аймгаар авч үзвэл Баян-Өлгий 7.1 пункт, Баянхонгор 7.0 пункт, Булган 6.2 пункт, Ховд 5.8 пункт, Говь-Алтай 5.2 пунктээр тус бүр буурсан байна. Харин Улаанбаатар хотын хувьд бага боловсролтой хүн амын хувь 0.6 пунктээр өссөн байна.


ЗУРАГ 3.1.9. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БАГА БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН



Мөн дээд боловсролтой арав, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн өөрчлөлтийг өмнөх тооллоготой харьцуулахад Баян-Өлгий 10.4 пункт, Ховд 9.5 пункт, Дархан-Уул 9.4 пункт, Улаанбаатар хотын эзлэх хувь 9.2 пунктээр өссөн байна.



ЗУРАГ 3.1.10. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН



3.2 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ

Монгол Улс сүүлийн 10 жилийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих зорилгоор нилээд олон эрх зүйн баримт бичгийг боловсруулж, сайжруулж байгаа билээ. Жишээлбэл, Монгол Улсын Их Хурлаас 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинээр баталж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн гишүүний хувьд үндсэн эрхээ эдэлж, хөгжих боломж олгосон суурь эрх зүйн баримт бичиг болсон юм. Энэ хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хуульчилж эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлыг зохицуулсан. Мөн Засгийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлж, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2018 онд байгуулсан юм.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох нөхцөлийг бүрдүүлэх, тэдний дуу хоолойг нь олон нийт, шийдвэр гаргах түвшинд хүргэх хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулсан байдаг. Тус хөтөлбөр нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025), Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны




хөтөлбөр зэрэг хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны бодлогын баримт бичиг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн зорилт 2-ын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн талаар нилээдгүй олон зүйл, заалтууд орсон байгаа нь цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүх шатны боловсрол олгох сургалтад хамрагдах явц сайжирч улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын түвшин нэмэгдэхэд түлхэц үзүүлэх юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд 106.4 мянга болж өмнөх тооллогоос 1.6 хувиар буурчээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 101.5 мянга нь 10, түүнээс дээш настай байна. 10, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 87.3 мянга (86.1 хувь) нь боловсролтой буюу ямар нэг түвшний боловсрол эзэмшсэн бөгөөд энэ үзүүлэлт өмнөх тооллогоос 8.1 пунктээр буурсан байна. Боловсролын түвшнээр нь авч үзвэл 21.3 хувь нь суурь, 29.9 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь техникийн болон мэргэжлийн дунд, 5.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 11.4 хувь нь дээд боловсролтой байна (ЗУРАГ 3.2.1). Өмнөх тооллогоос суурь боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувь 2.7 пунктээр, бүрэн дунд боловсролтой 4.8 пунктээр, дээд боловсролтой 3.7 пунктээр тус бүр нэмэгдсэн байна. Эндээс үзэхэд сүүлийн 10 жилд хөгжлийн бэрхшээлтэй иргэд боловсрол эзэмших нь нэмэгдсэн байна.

ЗУРАГ 3.2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН




Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 86.5 хувь нь, эмэгтэйчүүдийн 85.6 хувь нь ямар нэг түвшний боловсролтой байна. Боловсролын түвшин хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн 14.1 хувь нь бага, 23.1 хувь нь суурь, 30.0 хувь нь бүрэн дунд, 4.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 9.9 хувь нь дээд боловсролтой, эмэгтэйчүүдийн 13.7 хувь нь бага, 19.3 хувь нь суурь, 29.8 хувь нь бүрэн дунд, 3.6




хувь нь техникийн болон мэргэжлийн, 6.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 13.2 хувь нь дээд боловсролтой байна. Дээд боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллээс харахад дээд боловсролтой эмэтэйчүүд хувь эрэгтэйчүүдийнхээс 3.3 пунктээр илүү байна.

ЗУРАГ 3.2.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮИС, ХУВИАР, 2020 ОН



Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 89.4 хувь нь хотын, 81.0 хувь нь хөдөөгийн хүн амын боловсролтой буюу ямар нэг түвшний боловсролтой байна. Хөдөө орон нутагт амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бага болон суурь боловсролд хамрагдаж байгаа хэдий ч үргэлжлүүлэн суралцаж бүрэн дунд, дээд боловсролд хамрагдах явц нь хотын иргэдээс бага байна. Магадгүй орон нутагт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бүрэн дунд болон дээд боловсрол эзэмшүүлэх байгууллага байдаг учир орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд суурь боловсрол эзэмшээд суралцахаа зогсоож байх магадлалтай юм.

ЗУРАГ 3.2.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН





Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй боловсролгүй хүн амыг насны бүлгээр авч үзвэл 13.2 хувь нь 10-19 насныхан, 18.3 хувь нь 20-29 насныхан, 25.6 хувь нь 30-39 насныхан, 20.1 хувь нь 40-49 насныхан, 15.9 хувь нь 50-59 насныхан, 6.9 хувь 60, түүнээс дээш насныхан байна.

ХҮСНЭГТ 3.2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ, БОЛОСРОЛЫН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Боловсрол-гүй	Боловсрол-той	Боловсролын түвшин					
			Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
10-14	8.7	2.3	14.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
15-19	4.5	2.9	2.2	8.1	1.4	1.3	0.3	0.1
20-24	7.6	4.1	3.4	4.0	4.9	5.1	1.6	4.0
25-29	10.7	5.7	4.8	4.4	5.6	7.0	2.6	10.7
30-34	12.0	7.6	7.4	6.0	7.9	5.2	3.4	12.8
35-39	13.6	9.4	11.7	8.8	9.4	4.6	2.9	12.5
40-44	10.9	11.0	10.0	13.2	11.9	6.1	5.3	10.0
45-49	9.2	13.7	8.2	15.1	16.2	14.6	14.0	10.7
50-54	8.8	16.0	9.4	15.8	18.2	21.8	23.6	12.7
55-59	7.1	14.5	9.8	14.0	14.7	20.7	23.3	13.9
60+	6.9	12.8	18.7	10.6	9.8	13.6	23.0	12.6

Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг боловсролын түвшинг аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар хотын 91.0 хувь нь, Дархан-Уул аймгийн 89.8 хувь нь, Сэлэнгэ аймгийн 89.2 хувь нь, Орхон аймгийн 89.1 хувь нь, Баян-Өлгий аймгийн 88.4 хувь нь, Говьсүмбэр аймгийн 88.2 хувь нь боловсролтой байна.

Хөгжлийн бэрхшээлтэй боловсролгүй хүн амын эзлэх хувийг өмнөх тооллогын дүнтэй харьцуулж харахад Увс, Архангай, Баян-Өлгий, Дорнод, Дундговь аймгуудад ихээхэн өөрчлөлт орж өмнөх тооллогоос 13.0-18.7 пунктээр буурсан байна.

Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 18.6 хувь нь, Дархан-Уул аймгийн 13.5 хувь нь, Орхон аймгийн 12.7 хувь нь, Говьсүмбэр аймгийн 12.5 хувь нь дээд боловсролтой байна. Мөн бүрэн дунд боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувь Улаанбаатар, Орхон, Дархан аймгуудад илүү өндөр байна. Үүнээс үзэхэд хүн амын нягтрал ихтэй, хотжилт явагдсан аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын түвшин бусад аймгуудаас хамаагүй өндөр байна (Хүснэгт 3.2.1).



ХҮСНЭГТ 3.2.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Боловсрол- гүй	Боловсрол- той	Боловсролын түвшин					
			Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
БҮГД	13.9	86.1	13.9	21.3	29.9	4.2	5.4	11.4
Архангай	18.9	81.1	23.8	26.5	19.5	3.4	3.1	4.8
Баян-Өлгий	11.6	88.4	22.3	25.3	25.9	4.7	2.5	7.7
Баянхонгор	16.7	83.3	17.2	31.2	21.4	3.7	3.2	6.6
Булган	17.0	83.0	18.5	29.4	20.8	3.1	4.0	7.3
Говь-Алтай	15.4	84.6	17.4	27.0	23.7	4.3	3.9	8.3
Дорноговь	16.5	83.5	14.5	26.9	23.2	5.0	5.1	8.9
Дорнод	14.1	85.9	13.8	28.6	27.5	3.6	4.8	7.7
Дундговь	23.6	76.4	21.6	25.6	14.7	3.5	4.0	7.1
Завхан	17.3	82.7	17.3	28.9	23.2	4.2	2.7	6.4
Өвөрхангай	19.5	80.5	23.8	27.8	17.4	2.9	2.6	6.1
Өмнөговь	20.7	79.3	17.5	26.4	19.4	3.5	4.0	8.6
Сүхбаатар	22.9	77.1	21.3	25.6	14.5	5.8	4.3	5.7
Сэлэнгэ	10.8	89.2	11.8	28.2	31.2	5.8	5.5	6.7
Төв	17.4	82.6	17.5	29.0	19.6	5.8	4.4	6.1
Увс	18.5	81.5	18.4	23.8	21.4	5.3	3.9	8.7
Ховд	19.8	80.2	17.8	23.0	23.1	3.4	4.6	8.3
Хөвсгөл	19.1	80.9	23.8	24.6	22.2	2.0	3.5	4.9
Хэнтий	20.6	79.4	18.6	26.6	21.8	2.8	3.7	5.9
Дархан-Уул	10.2	89.8	7.8	17.7	36.8	5.9	8.2	13.5
Орхон	10.9	89.1	8.3	15.8	40.0	5.2	7.2	12.7
Говьсүмбэр	11.8	88.2	13.8	22.5	27.7	5.5	6.3	12.5
Улаанбаатар	9.0	91.0	7.1	13.0	40.8	4.1	7.5	18.6

3.3 БОЛОВСРОЛ БА ШАШИН

Шашин бол зөвхөн сүсэг бишрэл, итгэл үнэмшил төдийгүй хүн төрөлхтний соёл, оюун санааны хөгжил, төлөвшлийн чухал үзэгдэл байдаг. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоос эхлэн хүн амын шашин шүтлэг, боловсролын түвшний хамаарлыг судалж байгаа билээ. Монгол оронд ардчилсан хөдөлгөөн өрнөж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх болсноор шашин шүтлэг чөлөөтэй болсон. Шашныг ухамсартайгаар шүтэх нь түүний нөлөөнд хэт автахгүй, мухар сүсэг бишрэлээс хол байх сайн талтай. Иймд чухам ямар боловсролтой хүмүүсийн дунд шашин шүтлэг өндөр байна вэ гэдгийг авч үзэх нь нийгмийн ач холбогдолтой юм.


Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш настай нийт хүн амын 61.4 хувь нь ямар нэгэн шашин шүтдэг байсан бол 2020 оны тооллогоор 59.5 хувь болж 1.9 пунктээр буурсан байна. Шашин шүтдэг 15, түүнээс дээш насны хүн амын 87.1 хувь нь Будда, 5.4 хувь нь Ислам, 4.2 хувь нь Бөө, 2.2 хувь нь Христ, үлдсэн 1.1 хувь нь бусад төрлийн шашин шүтдэг байна.

Тооллогын дүнгээс үзэхэд боловсролгүй болон бага, суурь боловсролын түвшинтэй шашин шүтдэг хүн амын хувь өмнөх тооллогоос өссөн дүнтэй байгаа




бол бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд, магистр, докторын түвшинд буурсан байна. 2010 оны тооллогын дүнгээр харахад боловсролын түвшин ахихад шашин шүтдэг хүний эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байсан бол 2020 оны тооллогоор боловсролын түвшин ахих тусам шашин шүтдэг хүний эзлэх хувь буурсан байна (ЗУРАГ 3.3.1).

ЗУРАГ 3.3.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



Арван тав, түүнээс дээш насны нийт эрэгтэйчүүдийн 56.7 хувь нь, эмэгтэйчүүдийн 61.9 хувь нь шашин шүтдэг байна. Аль ч боловсролын түвшний хувьд эрэгтэйчүүдийн шашин шүтлэг нь эмэгтэйчүүдийнхээс бага байна. Боловсролгүй эрэгтэйчүүдийн 57.3 хувь нь, эмэгтэйчүүдийн 62.3 хувь нь, бага боловсролтой эрэгтэйчүүдийн 70.7 хувь нь, эмэгтэйчүүдийн 78.8 хувь нь шашин шүтдэг байна. Эндээс үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэй шашин шүтдэг нь харагдаж байна (ЗУРАГ 3.3.2).

ЗУРАГ 3.3.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН






3.4 ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх зөвлөмжийг өмнөх тооллогуудтай адил 2020 оны тооллогод баримталсан. Аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж ойлгодог, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн. Тооллогод боловсролгүй хүнээс бичиг үсгийн мэдлэгийг асуусан. Бичиг үсгийн мэдлэгийн талаарх асуултыг 5, түүнээс дээш насны бүх хүнээс асуусан ч Монгол Улсын хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшнийг олон улстай харьцуулагдахуйц байдлыг ханган 15, түүнээс дээш насаар тодорхойлов.

Хүн амын бичиг үсгийн мэдлэг байнга өсөж ирсний дотор бичиг үсэгтний хувь 1921 онд 2.1 байсан бол 1944 онд 27.3 хувь, 1956 онд 70.5 хувь болж огцом өсөөд 1979 онд 92.7 хувь, 1989 онд 96.5 хувь, 2000 онд 97.8 хувь, 2010 онд 98.3, 2020 онд 98.7 хувь болж тус тус өсжээ (ЗУРАГ 3.4.1). Хүн амын бичиг үсгийн мэдлэгийг хүйсээр нь авч үзвэл, эрэгтэйчүүдийн 98.6 хувь, эмэгтэйчүүдийн 98.9 хувь нь мэдлэгтэй байна.

ЗУРАГ 3.4.1. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР, 1921-2020 ОН




Монгол Улсын анхны (1924 он) болон 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудад Монгол Улсын иргэдийг эрэгтэй, эмэгтэй, шашин шүтлэг, өмч хөрөнгийн хэмжээ, нийгмийн гарал үүслийг ялгаварлахгүйгээр үнэ төлбөргүй сургах тухай заалт оруулж, түүнийг нь үе үеийн төр, засгийн газрууд ээлж дараатайгаар хэрэгжүүлсний үр дүн юм.

Тухайлбал хүн амын бичиг үсгийн мэдлэг 1945-1955 онуудад огцом өссөн нь 1941 онд МАХН-ын Төв хорооноос иргэдийг нийтээр нь бичиг үсэгт түргэн сургах зорилт дэвшүүлэн тавьсан, 1955 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв Хорооноос “Насанд хүрэгсдийг сургах оройн сургууль байгуулах тухай” хамтарсан тогтоол гаргаж амьдралд амжилттай хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр хүн амын бичиг үсгийн мэдлэгийг насны бүлгээр нь авч үзвэл, 30-34 нас, 35-39 нас, 55-59 нас, 70, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг улсын дүнгээс доогуур байна.




ЗУРАГ 3.4.2. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН



Хүн амын бичиг үсгийн мэдлэгийг хот, хөдөөгөөр авч үзвэл хөдөөний хүн амын 97.6 хувь, хотын хүн амын 99.3 хувь нь бичиг үсгийн мэдлэгтэй байна. Хотын 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг насны бүлэг бүрт жигд 99.0 хувиас дээш байгаа бол хөдөөнийг хүн амын насны бүлгүүдэд харилцан адилгүй байна. Хотын хүн амын бичиг үсгийн мэдлэг хөдөөгийн хүн амаас насны бүлэг бүрт өндөр байна. Жишээлбэл, 35-39 насанд 2.8 пункт, 30-34 насанд 2.6 пункт, 25-29 насанд 2.0 пункт, 70, түүнээс дээш насанд 3.7 пунктээр тус бүртээ хөдөөнөөс их байна .


ЗУРАГ 3.4.3. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН



Мөн бичиг үсгийн мэдлэгийг хүйс, насны бүлгээр авч үзэхэд 15-59 хүртэлх насны эмэгтэйчүүдийн боловсрол эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бол 60, түүнээс дээш насанд бага байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн зөрүү 35-39 насанд хамгийн их байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн бичиг үсэг мэдлэгийн хувь эрэгтэйчүүдийнхээс тухайн насанд 0.8 пунктээр өндөр байна. Харин 70, түүнээс дээш насанд эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг 99.1 хувь байгаа бол эмэгтэйчүүдийн 2.4 пунктээр бага байна.




ЗУРАГ 3.4.4. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН



Арван тав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшинг аймаг, нийслэлээр авч үзэхэд хамгийн өндөр хувьтай нь Дархан-Уулд 99.3, Орхонд 99.2, Өмнөговьд 99.1, Сэлэнгэд 98.6, Булган, Төв, Баян-Өлгийд тус бүр 98.5 хувь байна. Харин Сүхбаатарт 95.7, Хэнтийд 97.2, Увсад 97.3, Өвөрхангайд 97.5 хувь байгаа нь бичиг үсгийн мэдлэгийн түвшин харьцангуй доогуур байна (ЗУРАГ 3.4.5). Улаанбаатар болон нягтрал ихтэй хотжилт явагдсан аймгууд болох Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймгуудын хүн амын бичиг үсгийн мэдлэг улсын дунджаас дээгүүр байна.

Бичиг үсгийн мэдлэгийн түвшинг өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад, Архангай 1.9 пунктээр, Сүхбаатар 1.7 пунктээр, Дундговь 1.7 пунктээр, Завхан 1.3 пунктээр, Баянхонгор 1.2 пунктээр тус бүр нэмэгдсэн буюу хамгийн их өөрчлөлт орсон байна. Харин Орхон, Говьсүмбэр, Улаанбаатар хотын 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгт өөрчлөлт ороогүй байна.

ЗУРАГ 3.4.5. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2020 ОН





ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛ



4.1 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Хүн ам, орон сууцны тооллогоор хүн амын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг гаргах нь хэд хэдэн шалтгаантай байдаг. Хүн амын эдийн засгийн талаарх мэдээлэл нь тухайн улс орны эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн хэв маяг, зах зээлийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Мөн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн гол үзүүлэлтүүдийг тооллогоор цуглуулан хувь хүний болон өрх, орон сууцны нөхцөлийн үзүүлэлтүүдтэй холбосноор нийгэм, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.


Хүн амын асуулгын эдийн засгийн үзүүлэлтүүдийн ойлголт тодорхойлолтыг боловсруулахдаа НҮБ-ын “Хүн ам, орон сууцны 2020 он орчмын тооллогод баримтлах зарчим, зөвлөмж- III”-ийг үндэслэсэн. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолсон аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 15, түүнээс дээш насны хүн амаас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултуудыг асуусан.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдийн олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон. Уламжлалт тооллогын асуулгаар “Тооллогын товын үед ажил эрхэлж байгаа эсэх, товоос өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин хөлстэй ажил эрхэлсэн болон тухайн хугацаанд ажил эрхлээгүй боловч ер нь ажилтай хүнийг “Ажил эрхэлдэг” гэж үзсэн. Харин бүртгэлд суурилсан мэдээлэл боловсруулалтад Хүн ам, өрхийн мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон Гадаадын иргэн харьяатын газрын гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн сантай уялдуулан ажил эрхэлдэг хүнийг гаргасан.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын 53.6 хувь нь ажил эрхэлж байгаа бөгөөд өмнөх тооллогоос 2.7 пунктээр нэмэгдсэн байна. Ажил эрхэлдэг хүн амын 39.2 хувь нь дээд, 5.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 4.9 хувь нь техникийн болон мэргэжлийн дунд, 28.5 хувь нь бүрэн дунд, 14.9 хувь нь суурь, 6.0 хувь нь бага боловсролтой, 1.4 хувь нь боловсролгүй байна. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 15, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг бага боловсролтой хүн амын хувь 2.6 пунктээр, суурь 1.3 пунктээр, бүрэн дунд 2.9 пунктээр, тусгай мэргэжлийн дунд 2.3 пунктээр буурсан бол техникийн болон мэргэжлийн 1.3 пунктээр, дээд боловсролтой хүний хувь 10.0 пунктээр өссөн дүнтэй байна. Ажил эрхэлдэг хүмүүсийн хувьд 2010 онд 3.6 хувь нь боловсролгүй байсан бол 2020 онд 1.4 хувь болж 2.4 пунктээр буурсан байна (Зураг 4.1.1). Дээд боловсролтой хүн амын эзлэх хувь 2000 оны тооллогоос 3.2 дахин, өмнөх тооллогоос 10.0 пунктээр нэмэгдсэн байгаа нь сүүлийн 20 жилийн хугацаанд бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын тоо нэлээд өссөнтэй холбоотойгоос гадна хөдөлмөрийн зах зээлд бүрэн дунд болон дээд боловсролтой хүний эрэлт бусдаас илүү байгааг харуулж болохоор байна.



ЗУРАГ 4.1.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



Ажил эрхэлдэг 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг хүйсээр нь ангилж үзэхэд эрэгтэйчүүдийн 7.6 хув нь бага, 17.7 хувь нь суурь, 31.6 хувь нь бүрэн дунд, 5.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 30.9 хувь нь дээд боловсролтой байна. 2010 оны хүн амын тооллогын дүнтэй харьцуулж үзэхэд бага боловсролтой эрэгтэйчүүдийн хувь 3.0 пунктээр, суурь 1.3 пунктээр, бүрэн дунд 1.3 пунктээр, тусгай мэргэжлийн дунд 0.8 пунктээр буурсан бол техникийн болон мэргэжлийн 1.8 пунктээр, дээд боловсролтой хүний хувь 7.4 пунктээр өссөн дүнтэй байна (Зураг 4.1.2).

ЗУРАГ 4.1.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН




Мөн ажил эрхэлдэг 15, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 4.3 хувь нь бага, 11.8 хувь нь суурь, 24.9 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 48.5 хувь нь дээд боловсролтой байна. 2010 оны хүн амын тооллогын дүнтэй харьцуулж үзэхэд бага боловсролтой эмэгтэйчүүдийн хувь 2.0 пунктээр, суурь 1.1 пунктээр, бүрэн дунд 4.7 пунктээр, тусгай мэргэжлийн дунд 4.2 пунктээр буурсан бол техникийн болон




мэргэжлийн 0.8 пунктээр, дээд боловсролтой хүний хувь 12.5 пунктээр өссөн дүнтэй байна (Зураг 4.1.3).

ЗУРАГ 4.1.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЭМЭГТЭЙЧҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



Өмнөх тооллогоор арван тав, түүнээс дээш насны ажил хөдөлмөр эрхэлдэг боловсролгүй хүн амын 46.3 хувь нь бичиг үсэг мэддэггүй байсан бол 2020 оны хүн амын тооллогоор 29.9 хувь болж 16.4 пунктээр буурчээ.

ЗУРАГ 4.1.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛГҮЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН



Боловсролгүй ажил эрхэлдэг хүн амын 16.0 хувь нь хотод, 84.0 хувь нь хөдөө байна. Хөдөө ажил эрхэлдэг боловсролгүй хүн амын 75.4 хувь нь бичиг үсгийн мэдлэгтэй бөгөөд үүний 65.6 хувь нь эрэгтэй, 34.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин хотын хөдөлмөр эрхэлдэг боловсролгүй хүн амын 75.4 хувь нь бичиг үсгийн мэдлэгтэй байгаа бөгөөд 71.5 хувь нь эрэгтэй, 28.5 хувь нь эмэгтэй байна.

Хүн амын төвлөрөл ихтэй Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгуудын 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд эзлэх боловсролтой хүн амын хувь улсын дунджаас өндөр байна.



Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын 39.2 хувь нь дээд боловсролтой байгаа бол Улаанбаатар хотын 2 хүн тутмын нэг (54.6 хувь) нь, Дархан-Уул (45.2 хувь), Орхон (43.7 хувь нь) аймгуудын 5 хүн тутмын хоёр нь дээд боловсролтой байна.

ХҮСНЭГТ 4.1.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Боловсрол-гүй	Боловсрол-той	Боловсролын түвшин					
			Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
БҮГД	1.4	98.6	6.0	14.9	28.5	4.9	5.1	39.2
Архангай	2.0	98.0	15.2	29.8	24.9	4.4	3.2	20.5
Баян-Өлгий	3.3	96.7	16.1	18.1	20.6	5.3	3.8	32.9
Баянхонгор	2.0	98.0	9.2	34.6	24.8	5.1	3.2	21.2
Булган	1.4	98.6	8.2	29.3	29.3	4.3	4.0	23.6
Говь-Алтай	2.4	97.6	10.9	26.4	24.1	6.2	4.1	25.9
Дорноговь	1.5	98.5	6.0	18.9	26.9	7.8	7.0	32.0
Дорнод	1.6	98.4	5.1	19.8	29.1	6.7	6.5	31.2
Дундговь	2.4	97.6	15.7	30.8	17.9	6.5	4.5	22.1
Завхан	4.5	95.5	11.1	22.7	23.8	5.8	3.9	28.2
Өвөрхангай	2.6	97.4	18.6	28.8	21.6	4.6	2.9	20.9
Өмнөговь	1.9	98.1	8.7	23.4	25.7	6.5	4.7	29.2
Сүхбаатар	4.3	95.7	14.3	28.7	19.2	8.2	4.2	21.1
Сэлэнгэ	0.8	99.2	2.9	17.5	35.1	8.4	6.3	28.9
Төв	1.2	98.8	6.8	28.0	28.0	7.4	4.9	23.8
Увс	3.6	96.4	15.2	22.4	21.2	6.8	3.6	27.3
Ховд	3.1	96.9	7.9	22.2	26.0	4.4	5.4	31.0
Хөвсгөл	3.4	96.6	16.3	22.9	28.7	3.1	3.6	22.0
Хэнтий	2.4	97.6	8.6	25.9	27.2	5.5	4.0	26.4
Дархан-Уул	0.6	99.4	1.2	7.8	32.5	7.1	7.1	43.7
Орхон	0.5	99.5	1.2	6.0	35.9	5.5	5.8	45.2
Говьсүмбэр	0.8	99.2	3.5	13.7	28.4	7.8	8.6	37.2
Улаанбаатар	0.3	99.7	0.7	4.0	31.1	3.7	5.6	54.6

*Гадаадын иргэдийн мэдээлэл ороогүй болно.

4.2 АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ХҮН АМ БОЛОН АЖИЛГҮЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Ажилгүй хүн гэдгийг тодорхойлоход хүн амын тооллогын асуулгын хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан, мөн сүүлийн 30 хоногт цалин хөлстэй ажил хайх (бизнес эрхлэх) ямар нэгэн оролдлого хийсэн эсэхийг тодруулсан. Ажил хайж байгаа гэдэгт тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс бүртгэлтэй болон бүртгэлтгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг хамааруулж, ажилгүйчүүдийг тодорхойлсон.


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн 95.8 хувь нь, эмэгтэйчүүдийн 96.3 хувь ямар нэг



түвшний боловсролтой байна. Ажилгүй эрэгтэйчүүдийн 2.9 хувь нь бага, 26.6 хувь нь суурь, 35.3 хувь нь бүрэн дунд, 8.4 хувь нь техникийн болон мэргэжлийн, 7.0 хувь нь тусгай мэргэжлийн, 15.7 хувь нь дээд, эмэгтэйчүүдийн 3.9 хувь нь бага, 19.7 хувь нь суурь, 32.5 хувь нь бүрэн дунд, 7.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 10.6 хувь нь тусгай мэргэжлийн, 22.3 хувь нь дээд боловсролтой байна. Тоон мэдээллээс харахад ажилгүй 3 эрэгтэй тутмын хоёр (61.9 хувь) нь, 2 эмэгтэй тутмын нэг (52.2 хувь) нь суурь болон бүрэн дунд боловсролтой байна. Суурь болон бүрэн дунд боловсролтой эрэгтэйчүүдийн хувь ажилгүйдэлд өртөх магадлал өндөр харагдаж байна. Эцэг, эхчүүд эмэгтэй хүүхдээ өндөр боловсролтой болгох хүсэл, хандлага нэмэгдсэн. Тооллогын дүнгээс харахад ажилгүй байгаа 5 эмэгтэй тутмын нэг (22.3 хувь) нь дээд боловсролтой байгаа нь анхаарал татахуйц байна.

2010 оны тооллогоор ажил эрхэлдэггүй боловсролгүй хүн амыг 53.7 хувь бичиг үсэг мэддэг байсан бол 2020 онд 48.5 хувь болж өмнөх тооллогоос 5.2 пунктээр буурсан байна.


ЗУРАГ 4.2.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ, БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН



Ажил эрхэлдэггүй хүн амын 3.9 хувь нь боловсролгүй, 3.5 хувь нь бага, 22.5 хувь нь суурь, 33.6 хувь нь бүрэн дунд, 7.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 9.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 19.7 хувь нь дээд боловсролтой байна. Дээд боловсролтой ажилгүй хүн амын 13.0 хувь нь дипломын дээд, 79.9 хувь нь бакалаврын дээд, 6.4 хувь нь магистр, 0.7 хувь нь доктор зэрэгтэй байна. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулж үзэхэд бүрэн дунд боловсролтой ажилгүй хүн амын хувь 6.6 пунктээр буурсан хэдий ч дээд боловсролтой ажилгүй хүн амын хувь 7.0 пунктээр өссөн байна. Сүүлийн жилүүдэд ажлын байранд дээд боловсролтой, мэргэжил эзэмшсэн хүнийг авах хандлага ихээхэн нэмэгдсэнтэй холбоотойгоор суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүсийн хувьд ажилгүйдэлд өртөх магадлал өндөр байна. Мөн сүүлийн 10 жилийн хугацаанд хувийн их, дээд сургууль, коллежийн тоо олширч тэдгээрт элсүүлэх мэргэжлийн чиглэл, хэрэгцээ, тоо хэмжээг оновчтой төлөвлөн тогтоодоггүйгээс шалтгаалан боловсролын чанар муудаж ажилгүй дээд боловсролтой хүмүүсийн тоо нэмэгдэх чиг хандлага ажиглагдаж байна.




ЗУРАГ 4.2.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСЫН АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн 95.8 хувь нь, эмэгтэйчүүдийн 96.3 хувь ямар нэг түвшний боловсролтой байна.

Ажилгүй эрэгтэйчүүдийн 2.9 хувь нь бага, 26.6 хувь нь суурь, 35.3 хувь нь бүрэн дунд, 8.4 хувь нь техникийн болон мэргэжлийн, 7.0 хувь нь тусгай мэргэжлийн, 15.7 хувь нь дээд боловсролтой байна. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулж үзэхэд техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд, дээд боловсролтой хүний эзлэх хувь нэмэгдсэн байна.


ЗУРАГ 4.2.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



Харин ажилгүй эмэгтэйчүүдийн 3.9 хувь нь бага, 19.7 хувь нь суурь, 32.5 хувь нь бүрэн дунд, 7.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 10.6 хувь нь тусгай мэргэжлийн, 22.3 хувь нь дээд боловсролтой байна.




ЗУРАГ 4.2.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2010, 2020 ОН



Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй боловсролгүй хүн амын 48.5 хувь нь бичиг үсгийн мэдлэгтэй, 51.5 хувь нь бичиг үсэг мэддэггүй байна. Ажил эрхэлдэггүй боловсролгүй хүн амын хүйсээр нь ангилж үзэхэд эрэгтэйчүүдийн 45.1 хувь нь, эмэгтэйчүүдийн 51.0 хувь нь бичиг үсэг мэддэг байна. Мөн ажил эрхэлдэггүй бичиг үсэг мэддэг хүн амын 39.6 хувь нь, бичиг үсэг мэддэггүй хүн амын 45.3 хувь нь эрэгтэйчүүд байна. Тоон мэдээллээс харахад боловсролгүй эмэгтэйчүүд ажилгүйдэл өртөх магадлалтай байна.

ЗУРАГ 4.2.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН



Арван тав, түүнээс дээш насны дээд боловсролтой ажилгүй хүн амын эзлэх хувь Улаанбаатар (26.7 хувь), Орхон (17.9 хувь), Дархан-Уул (16.9 хувь), Баян-Өлгий (16.7 хувь) аймагт бусад аймгаас илүү, харин Хөвсгөл (9.1 хувь), Хэнтий (8.9 хувь), Сүхбаатар (7.7 хувь) аймагт бусад аймгаас бага байна. Мөн бүрэн дунд боловсролтой ажилгүй хүн амын эзлэх хувь Орхон (43.0 хувь), Улаанбаатар (42.3 хувь), Дархан-Уул (40.1 хувь), Сэлэнгэ (39.9 хувь) аймагт бусад аймгаас илүү



өндөр байна. Өөрөөр хэлбэл Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын 15, түүнээс дээш насны ажилгүй 5 хүн тутмын хоёр нь бүрэн дунд боловсролтой байна. Тухайн аймгууд нь хүн амын нягтрал ихтэй бусад аймгуудыг бодвол хотжилт их явагдсан тул дагаад хүн амын боловсролын түвшин өндөр байдагтай холбож болох юм.

ХҮСНЭГТ 4.2.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Боловсрол- гүй	Боловсрол- той	Боловсролын түвшин					
			Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
БҮГД	2.6	97.4	6.9	24.1	38.1	3.7	5.6	19.1
Архангай	3.5	96.5	12.5	32.7	33.9	3.1	3.9	10.4
Баян-Өлгий	3.9	96.1	12.3	30.5	28.9	4.4	3.3	16.7
Баянхонгор	3.9	96.1	12.4	33.4	33.2	4.2	3.8	9.3
Булган	2.5	97.5	10.6	34.9	32.4	3.4	4.5	11.7
Говь-Алтай	3.6	96.4	12.1	30.8	33.6	4.1	3.8	11.9
Дорноговь	3.1	96.9	8.7	31.1	33.2	4.8	6.5	12.6
Дорнод	3.1	96.9	8.4	33.6	35.4	4.6	5.6	9.2
Дундговь	4.6	95.4	15.2	33.6	26.5	4.9	5.0	10.2
Завхан	5.5	94.5	11.2	30.7	32.9	4.2	3.9	11.6
Өвөрхангай	3.3	96.7	17.5	33.7	30.0	3.3	3.3	8.9
Өмнөговь	3.4	96.6	10.3	30.7	32.1	3.7	4.9	15.0
Сүхбаатар	5.7	94.3	14.1	33.1	26.4	7.0	6.0	7.7
Сэлэнгэ	2.1	97.9	5.9	31.1	39.9	5.6	5.7	9.6
Төв	2.6	97.4	9.4	34.9	31.4	5.5	5.3	10.9
Увс	4.8	95.2	10.2	32.1	32.4	5.3	3.9	11.4
Ховд	4.0	96.0	10.2	30.3	32.7	3.5	5.2	14.1
Хөвсгөл	4.9	95.1	15.1	29.6	35.7	2.3	3.4	9.1
Хэнтий	4.3	95.7	11.6	34.9	33.0	3.4	3.9	8.9
Дархан-Уул	1.9	98.1	4.5	23.4	40.1	5.5	7.5	16.9
Орхон	2.0	98.0	4.9	20.5	43.0	4.6	7.1	17.9
Говьсүмбэр	2.2	97.8	8.4	28.4	37.6	4.1	7.0	12.2
Улаанбаатар	1.6	98.4	3.1	16.9	42.3	3.0	6.4	26.7

4.3 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРТ АЖИЛЛАДАГ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын 24.8 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 12.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ, 9.9 хувь нь боловсрол, 8.2 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 7.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 5.9 хувь нь барилга, 5.0 хувь нь тээвэр агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны зарим салбараар ажил эрхэлдэг хүн амын боловсролын түвшинг авч үзвэл:



Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажилладаг хүн амын 4.5 хувь нь боловсролгүй, 20.7 хувь нь бага, 39.7 хувь нь суурь, 23.4 хувь нь бүрэн дунд, 4.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 2.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 5.1 хувь нь дээд боловсролтой байна.

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээний салбарт ажилладаг хүн амын 0.4 хувь нь боловсролгүй, 1.1 хувь нь бага, 6.6 хувь нь суурь, 35.6 хувь нь бүрэн дунд, 4.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 45.9 хувь нь дээд боловсролтой байна.

Боловсролын салбарт ажилладаг хүн амын 0.1 хувь нь боловсролгүй, 0.5 хувь нь бага, 3.3 хувь нь суурь, 15.6 хувь нь бүрэн дунд, 7.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 2.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 70.5 хувь нь дээд боловсролтой байна.

Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт ажилладаг хүн амын 0.3 хувь нь боловсролгүй, 0.9 хувь нь бага, 5.0 хувь нь суурь, 22.6 хувь нь бүрэн дунд, 3.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 7.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 60.6 хувь нь дээд боловсролтой байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажилладаг хүн амын 0.7 хувь нь боловсролгүй, 2.3 хувь нь бага, 10.1 хувь нь суурь, 39.9 хувь нь бүрэн дунд, 6.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 6.3 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 34.8 хувь нь дээд боловсролтой байна.


Тооллогын дүнгээс харахад санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт ажил эрхэлдэг 10 хүн тутмын найм нь, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, мэдээлэл холбоо, боловсролын салбарт ажил эрхэлдэг 10 хүн тутмын долоо нь дээд боловсролтой байна (Зураг 4.3.1).

Боловсролгүй хүн амын 78.4 хувь нь, бага боловсролтой хүн амын 84.9 хувь нь, суурь боловсролтой хүн амын 66.1 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллаж байгаа нь тухайн салбарт хөдөлмөр эрхлэгчид нь мэргэжилгүй хүмүүс болохыг илэрхийлж байна. Ажил эрхэлдэг боловсролгүй хүн амын 29.9 хувь нь бичиг үсэг мэддэггүй бол үүний 85.5 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 2.9 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 2.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ, 2.1 хувь нь барилга, үлдсэн 6.9 хувь нь бусад салбарт ажиллаж байна.

Ажил эрхэлдэг дээд боловсролтой хүн амын 17.9 хувь нь боловсрол, 14.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ, 12.6 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 6.9 хувь нь боловсруулах, 6.9 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажиллаж байна. Магистрын түвшний боловсролтой ажил эрхэлдэг хүн амын 32.8 хувь нь, докторын түвшний боловсролтой ажил эрхэлдэг хүн амын 54.1 хувь нь боловсролын салбарт байна.



ЗУРАГ 4.3.1. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛАЛ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН



Ажил эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, тээвэр агуулахын үйл ажиллагаа, барилга, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчдын 73-аас дээш хувь нь эрэгтэйчүүд байхад хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, боловсрол, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын 71-ээс дээш хувь нь эмэгтэйчүүд байна.

Дээд боловсролтой ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн 16.0 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 14.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ, 8.7 хувь нь барилга, 8.6 хувь боловсрол, 7.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 7.4 хувь нь уул уурхай, олборлолт, 5.8 хувь нь тээвэр агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллаж байна (Зураг 4.3.2).



ЗУРАГ 4.3.2. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ЭРЭГТЭЙЧҮҮД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХУВИАР, 2020 ОН



Харин дээд боловсролтой ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн 24.5 хувь нь боловсрол, 14.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ, 10.2 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 9.8 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 6.6 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 6.4 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 3.6 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт ажиллаж байна (Зураг 4.3.3).

ЗУРАГ 4.3.3. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ЭМЭГТЭЙЧҮҮД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХУВИАР, 2020 ОН





ТАВДУГААР БҮЛЭГ

ХҮН АМЫН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор тухайн хүний эзэмшсэн мэргэжлийг асууж тодруулсан нь өмнөх тооллогуудаас онцлогтой юм. Хүн амын орон сууцны тооллогод Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/150 тоот тушаалаар батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс болон Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/118 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын мэргэжлийн ангилал, кодоор хүн амын эзэмшсэн мэргэжлийг тодорхойлсон. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн мэргэжлийн ерөнхий чиглэл олон шинэчлэгдэж, өөрчлөгдсөн тул 2016 онд батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индексээр кодлоход ихээхэн бэрхшээлтэй байлаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр арван тав, түүнээс дээш насны хүн амын 26.9 хувь нь дээд сургууль, 23.8 хувь нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөж мэргэжил эзэмшсэн бол 49.2 хувь нь мэргэжилгүй байна.

5.1 ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖИЛ

Их, дээд сургууль төгсөгчдийн 6.9 хувь нь 2 мэргэжил, 1.1 хувь нь 3 мэргэжил, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн 2.7 хувь нь 2 мэргэжил, 0.6 хувь нь 3 мэргэжил эзэмшсэн байна (Хүснэгт 5.1.1).

Их, дээд сургууль нэг мэргэжлээр төгсөгчдийн 61.7 хувь нь, хоёр мэргэжлээр төгсөгчдийн 65.8 хувь нь, гурван мэргэжлээр төгсөгчдийн 65.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Өөрөөр хэлбэл дээд сургууль төгссөн 5 хүн тутмын гурав нь эмэгтэйчүүд байна.

Их, дээд сургууль нэг мэргэжлээр төгсөгчдийн 24.7 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй, 19.9 хувь нь боловсрол, 12.4 хувь нь инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт, 9.9 хувь нь урлаг, хүмүүнлэг, 8.7 хувь нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй, 8.4 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, 5.4 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, 4.7 хувь нь үйлчилгээ, 3.8 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй, 2.2 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна. Тооллогын дүнгээс харахад хоёр мэргэжилтэй 5 хүн тутмын нэг нь боловсрол, бизнес, удирдлага, эрх зүй, гурван мэргэжилтэй 5 хүн тутмын нэг нь бизнес, удирдлага, эрх зүйн чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна.

Их, дээд сургууль төгссөн эрэгтэй төгсөгчдийн 22.1 хувь нь инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт, 21.0 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй, 12.2 хувь нь боловсрол, 11.1 хувь нь урлаг, хүмүүнлэг, 7.9 хувь нь үйлчилгээ, 7.9 хувь нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй, 5.8 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, 4.6 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй, 3.9 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, 3.6 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна (Хүснэгт 5.1.1).



Харин эмэгтэй төгсөгчдийн 26.9 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй, 24.7 хувь нь боловсрол, 11.2 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, 9.3 хувь нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй, 9.2 хувь нь урлаг, хүмүүнлэг, 6.4 хувь нь инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт, 5.1 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, 3.3 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй, 2.7 хувь нь үйлчилгээ, 1.3 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 82.2 хувь нь, боловсролын чиглэлээр төгсөгчдийн 76.6 хувь нь, бизнес, удирдлага, эрх зүйн чиглэлээр төгсөгчдийн 67.4 хувь нь, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр төгсөгчдийн 65.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 5.1.1. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧИД, МЭРГЭЖЛИЙН ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛЭЭР, МЯНГАН ХҮН, 2020 ОН

Мэргэжлийн ерөнхий ангилал	Мэргэжил-1		Мэргэжил-2		Мэргэжил-3	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
БҮГД	584.1	360.3	40.2	26.4	6.4	4.1
Боловсрол	116.4	89.1	10.1	8.3	1.2	0.9
Урлаг, хүмүүнлэг	57.8	33.0	3.4	2.2	0.9	0.6
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	50.8	33.1	2.5	1.6	0.5	0.3
Бизнес, удирдлага, эрх зүй	144.0	97.1	11.6	7.6	1.5	1.0
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	31.4	18.4	1.5	0.9	0.4	0.3
Мэдээлэл, харилцаа холбооны технологи	12.6	4.6	0.5	0.2	0.1	0.0
Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	72.6	23.2	3.0	1.0	0.4	0.1
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй	22.1	11.8	1.5	0.8	0.5	0.3
Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	48.9	40.2	3.2	2.7	0.4	0.4
Үйлчилгээ	27.4	9.7	3.0	1.2	0.4	0.2

Арван тав, түүнээс дээш насны их, дээд сургууль төгсөгчдийн 10.1 хувь нь 24 хүртэлх, 20.0 хувь нь 25-29 нас, 19.6 хувь нь 30-34 нас, 12.7 хувь нь 35-39 нас, 9.4 хувь нь 40-44 нас, 7.3 хувь нь 45-49 нас, 5.9 хувь нь 50-54 нас, 5.6 хувь нь 55-59 нас, 9.8 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна. Тооллогын дүнгээс үзэхэд 15, түүнээс дээш насны их, дээд сургууль төгссөн 2 хүн тутмын нэг (49.8 хувь) нь 34 хүртэлх насны залуучууд байна. Энэ нь сүүлийн 10 жилийн хугацаанд эцэг, эхчүүд хүүхэддээ дээд боловсрол эзэмшүүлэх болсон байна (Хүснэгт 5.1.2).

Бизнес, удирдлага, эрх зүйн чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 9.5 хувь нь 24 хүртэлх, 20.7 хувь нь 25-29 нас, 38.7 хувь нь 30-39 нас, 16.5 хувь нь 40-49 нас, 8.5 хувь нь 50-59 нас, үлдсэн 6.1 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна.



Боловсролын чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 8.9 хувь нь 24 хүртэлх, 17.5 хувь нь 25-29 нас, 31.8 хувь нь 30-39 нас, 20.0 хувь нь 40-49 нас, 11.5 хувь нь 50-59 нас, 10.3 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна.

Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 12.6 хувь нь 24 хүртэлх, 22.0 хувь нь 25-29 нас, 29.0 хувь нь 30-39 нас, 13.7 хувь нь 40-49 нас, 13.5 хувь нь 50-59 нас, 9.2 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна.

Урлаг, хүмүүнлэг чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 10.6 хувь нь 24 хүртэлх, 17.5 хувь нь 25-29 нас, 28.7 хувь нь 30-39 нас, 16.9 хувь нь 40-49 нас, 14.1 хувь нь 50-59 нас, үлдсэн 12.2 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна.

Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 8.6 хувь нь 24 хүртэлх, 17.0 хувь нь 25-29 нас, 33.2 хувь нь 30-39 нас, 17.1 хувь нь 40-49 нас, 11.8 хувь нь 50-59 нас, 12.3 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 11.9 хувь нь 24 хүртэлх, 25.6 хувь нь 25-29 нас, 26.3 хувь нь 30-39 нас, 13.7 хувь нь 40-49 нас, 11.9 хувь нь 50-59 нас, 10.5 хувь нь 60, түүнээс дээш насныхан байна.

ХҮСНЭГТ 5.1.2. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧИД НАСНЫ БҮЛГЭЭР, МЭРГЭЖЛИЙН ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Мэргэжлийн ерөнхий чиглэл	Бүгд	Насны бүлэг								
		24 хүртэлх	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-аас дээш
БҮГД	100.0	10.1	20.0	19.6	12.7	9.0	7.3	5.9	5.6	9.8
Боловсрол	100.0	8.9	17.5	18.2	13.6	11.4	8.6	5.9	5.6	10.3
Урлаг, хүмүүнлэг	100.0	10.6	17.5	17.5	11.2	9.0	8.0	7.3	6.7	12.2
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	100.0	8.6	17.0	19.8	13.4	9.3	7.8	5.9	5.9	12.3
Бизнес, удирдлага, эрх зүй	100.0	9.5	20.7	23.6	15.1	9.7	6.8	4.6	3.9	6.1
